

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2026 оны 01 сарын 26 өдөр

№ 26/002.

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.6 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын цахим санал хураалтын дүнг тус тус үндэслэн тогтоох нь:

1. “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны цэвэр ашгаас Нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийн үндэслэлийг Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг сангийн Гүйцэтгэх удирдлагын итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Болор-Эрдэнэд үүрэг болгосугай.
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрлэсэн мэдээллийг зохих журмын дагуу Нэгж эрх эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Дөлгөөнд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Н.МОНСОП